

/ \_\_\_\_\_ / ХХК

/ \_\_\_\_\_ / ХХК

Хоорондын

**АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

## АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

...Оны.....сарын....өдөр

Улаанбаатар хот

Энэхүү барилгын ажил гүйцэтгэх гэрээ /цаашид “Гэрээ” гэх/-г Монгол Улсын иргэний хуулийн 343-358 дугаар зүйл, талуудын хүсэл зоригийг тус тус үндэслэн нэг талаас \_\_\_\_\_/\_\_\_\_\_ --цаашид “Захиалагч” гэх/, нөгөө талаас \_\_\_\_\_ - /цаашид гүйцэтгэгч, хамтад нь “Талууд” гэх/ нар дор дурьдсан нөхцлөөр харилцан тохиролцож байгуулав.

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Гэрээгээр Захиалагчаас энэ гэрээнд заасан \_\_\_\_\_-г гэрээнд заасан хугацааны дотор гүйцэтгүүлэхтэй холбогдон үүсэх харилцаа, Захиалагчаас Гүйцэтгэгчид ажлын зардлыг тодорхой хуваарийн дагуу олгох, ажлын гүйцэтгэлд хяналт тавихтай холбогдон үүсэх харилцааг тус тус зохицуулна.

1.2. Нэг талаас Захиалагч нь зардлыг Гэрээнд заасан хэмжээ, нөхцлөөр олгох, нөгөө талаас Гүйцэтгэгч нь гэрээнд заасан хугацаанд \_\_\_\_\_-г чанарын өндөр түвшинд гүйцэтгэхээр харилцан хүсэл зоригоо илэрхийлсний үндсэн дээр дор дурьдсан нөхцлүүдийг харилцан тохиролцов

### ХОЁР. ГЭРЭЭГЭЭР ТОХИРОЛЦСОН АЖИЛ

2.1. Ажлын үр дүн нь ..... болно.

### ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ

3.1. Гэрээний 2-д заасан ажлын нийт төлбөр \_\_\_\_\_ төгрөг байна.

3.2. Гэрээний төлбөрт ажлын гүйцэтгэлд холбогдох материалын болон бусад зардал, ажлын хөлс зэрэг гарч болох бүхий л төлбөр, зардлууд багтсан болно.

3.3. Захиалагч нь Гүйцэтгэгчид гэрээний төлбөрийг бэлнээр төлнө.

### ДӨРӨВ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

4.1. Ажлын эхлэх хугацаа оны ... дугаар сарын ...-ны өдөр, ашиглалтад хүлээлгэн өгөх хугацаа оны .... дугаар сарын ....-ны өдөр байх ба ажлын гүйцэтгэлийн үргэлжлэх хугацаа ... сар ... хоног байна.

4.2. Талууд гэрээний хугацааг нарийн чанд мөрдөн ажиллана.

### ТАВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

#### 5.1. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ:

- 5.1.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Гүйцэтгэгчээс шаардах;
- 5.1.2. Ажлын гүйцэтгэлийг шалгах бөгөөд чанаргүй хийсэн, дутуу хийсэн ажлыг гүйцээн хийхийг шаардах;
- 5.1.3. Гүйцэтгэгчид гэрээгээр тохиролцсон үнэ хөлсийг төлөх;
- 5.1.4. Гүйцэтгэсэн ажлын үр дүнг хугацаанд нь хүлээн авах;
- 5.1.4. Гүйцэтгэгчид энэхүү гэрээнд заасан үүргээ биелүүлэхэд нь шаардагдах бүхий л мэдээ, мэдээлэл, зааварчилгааг өгөх;

## **5.2. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ:**

- 5.2.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Захиалагчаас шаардах;
- 5.2.2. Гүйцэтгэгч нь Захиалагчийн өгсөн ажлыг өөрийн ур чадвартаа тулгуурлан чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэх;
- 5.2.3. Ажлын явцад болон дараа илэрсэн зөрчил, чанарын доголдлыг тухай бүр өөрийн хөрөнгөөр арилгах, нөхөн гүйцэтгэх;
- 5.2.4. Гэрээний 5.1-д заасан хугацааг чанд баримтлах;
- 5.2.5. Захиалагчийн өгсөн заавар, зөвлөмжийг анхааран ажиллах;
- 5.2.6. Захиалагчийн өмчлөлд ямар нэгэн доголдолгүй үр дүн шилжүүлэх;

## **ЗУРГАА. ГЭРЭЭНИЙ ХАРИУЦЛАГА**

- 6.1. Гүйцэтгэгч энэхүү гэрээний 4.1-д заасан хугацаанд ажлыг эцэслэн дуусгаагүй бол \_\_\_\_\_ төгрөгийн торгууль төлнө.
- 6.2. Талуудын аль нэг нь гэрээгээр тогтоосон хэм хэмжээг зөрчснөөс болж нөгөө талдаа хохирол учруулбал учруулсан хохирлоо бүрэн хариуцна.
- 6.3. Гэрээг зөрчсний улмаас маргаан үүсэж хууль зүйн туслалцаа авсан бол гэм буруутай тал нь Өмгөөллийн үйл ажиллагааны зардлыг гэрээнд заасан хэмжээгээр бүрэн хариуцана.

## **ДОЛОО. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ**

- 7.1. Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зөрөлдөөн, маргааныг Талууд зөвшилцөх аргаар шийдвэрлэнэ.
- 7.2. Хэрэв дээрх аргаар маргааныг шийдвэрлэж чадахгүй бол Монгол Улсын Шүүхээр шийдвэрлүүлнэ.

## **НАЙМ. БУСАД ЗҮЙЛ**

- 8.1. Гэрээ нь Талууд гарын үсэг зурж, баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 8.2. Гэрээнд Талууд тохиролцон хавсралтаар нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
- 8.3. Гэрээг \_\_\_\_\_ хувь үйлдэж, Талууд тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд эхүүд нь хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

## ЕС. ТАЛУУДЫН ХУУЛЬ ЁСНЫ ХАЯГ

9.1.Талууд гэрээ байгуулах өдрийн байдлаар дараах албан ёсны хаягт байрлаж байгаа бөгөөд хаяг өөрчлөгдсөн тохиолдолд нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ:

### 9.1.1: ЗАХИАЛАГЧ ТАЛ

Хаяг: \_\_\_\_\_,

Утас/Факс: \_\_\_\_\_,

Банкны данс: \_\_\_\_\_,

### 9.1.2: ГҮЙЦЭТГЭГЧ ТАЛ

Хаяг \_\_\_\_\_,

Утас/Факс: \_\_\_\_\_,

Банкны данс: \_\_\_\_\_,

## АРАВ.НУУЦЛАЛ

10.1. Аль нэг Тал компанийн бизнес төлөвлөгөө болон энэ гэрээний дагуу мэдэх болсон бусад Талуудын бизнесийн нууцлалыг чандлан хадгалах бөгөөд нууцлал задруулбал энэ гэрээний 6 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээнэ.

## АРВАН НЭГ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

11.1. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлсийн улмаас аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний үүргээ биелүүлэх хугацааг тухайн нөхцөл байдлыг арилах хүртэл хойшлуулна.

11.2. Энэхүү Гэрээний \_ заасан нөхцөл байдал үүссэн, дууссан талаар Талууд нэг нэгэндээ нэн даруй мэдэгдэх үүрэгтэй. Ийнхүү мэдэгдээгүйн улмаас нөгөө Талдаа учирсан хохирлыг буруутай Тал хариуцна.

11.3. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлс 60 хоногоос дээш хугацаагаар үргэлжилсэн, хэдийд дуусах нь тодорхойгүй тохиолдолд талууд харилцан тохиролцож гэрээг дуусгавар болгох эрхтэй.

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Захиалагч:

\_\_\_\_\_

Гүйцэтгэгч:

\_\_\_\_\_